



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/007/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа
Утас: 70518396
Аудитын менежер: М.Нарантуяа
Утас: 70512123
Аудитор: Ө.Золзаяа
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.17 № 293

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зардал 489.9 сая төгрөг буюу 99 хувийн гүйцэтгэлтэй ба Онгон сумын Засаг даргын баталсан 2024 оны зорилт түвшин, төлөвлөгөөг баримтлан үйл ажиллагаа хэрэгжүүлж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ.

Аудитын гол асуудал

Онгон Арвижих ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангаар 48.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ нь халаалт дулаан болон төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэн тогтоосон, зардлыг оновчтой төлөвлөж, хэмнэлт гаргасан нь нөлөөлжээ.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,436,379.10	21,674,264.28
1.1.2	Дансны авлага	1,087,003.00	4,544,420.00
1.1.6	Бараа материал	15,994,200.00	10,532,625.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	24,517,582.10	36,751,309.28
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,914,243,002.57	1,837,349,593.30
1.2.2	Биет бус хөрөнгө	4,538,400.00	4,538,400.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,918,781,402.57	1,841,887,993.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,943,298,984.67	1,878,639,302.58
2.1.1.1	Дансны өглөг	3,020,000.00	305,000.00
2.1.1.3	Татварын өр	8,855,473.58	11,345,424.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,884,719,790.94	1,771,525,503.54
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,896,595,264.53	1,783,175,927.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,896,595,264.53	1,783,175,927.55
2.3.1	Өмч: - төрийн	4,538,400.00	4,538,400.00
2.3.9	Тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	42,165,320.14	42,165,320.14
2.3.10	Тайлант үеийн хуримтлагдсан ашиг	0.00	48,759,654.89
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	46,703,720.14	95,463,375.03
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,943,298,984.67	1,878,639,302.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	328,738,598.71	540,580,841.28
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	156,144,545.00	327,672,986.93
3	Нийт ашиг (алдагдал)	175,148,599.16	212,907,854.35
4	Түрээсийн орлого	2,554,545.45	3,560,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	25,862,923.15	17,733,554.05
10	Ерөнхий ба удирдлагын зардал	209,096,893.83	144,466,906.50
11	Санхүүгийн зардал	0.00	89,999.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.00	54,177,394.32
19	Орлогын татварын зардал	0.00	5,417,739.43
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(61,409,234.26)	48,759,654.89
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	0.00	48,759,654.89
24	Орлогын нийт дүн	(104,682,738.26)	48,759,654.89

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,538,400.00	132,589,736.78	137,128,136.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,538,400.00	132,589,736.78	137,128,136.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-90,424,416.65	-90,424,416.65
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,538,400.00	42,165,320.13	46,703,720.13
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,538,400.00	-48,259,096.52	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,538,400.00	42,165,320.13	46,703,720.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	48,759,654.89	48,759,654.89
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,538,400.00	90,924,975.02	95,463,375.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	352,119,225.00	544,990,067.68
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	347,427,225.00	537,066,158.41
	Бусад мөнгөн орлого	4,692,000.00	7,923,909.27
1.2	Мөнгөн зарлага (-)	404,173,540.81	530,752,182.50
	Ажиллагчдад төлсөн	128,258,832.00	182,033,748.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	34,386,289.68	56,693,498.46
	Бараа материал худалдан авахад төлсөн	742,100.00	32,284,456.00
	Ашиглалтын зардалд төлсөн	79,429,681.16	65,788,115.65
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	123,244,546.00	112,396,430.00
	Татварын байгууллагад төлсөн	33,988,791.97	75,597,858.91
	Бусад мөнгөн зарлага	4,123,300.00	5,958,075.48
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,054,315.81)	14,237,885.18
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(52,054,315.81)	14,237,885.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	59,490,694.91	7,436,379.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,436,379.10	21,674,264.28

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.